

**“СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ БИЕЛЭЛТ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Биелэлт
АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД			
1	1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;	-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэрээрүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх;	-Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/264 дүгээр захирамжаар батлагдсан “Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэн сайн мэдэх вэ?” сэдэвт мэдлэг сорих асуулт, хариултын тэмцээнийг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх газар, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар хамтран Авлигын эсрэг “НЭГДЬЕ” аяны хүрээнд Сүхбаатар дүүргийн 14 төрийн байгууллагын дунд зохион байгуулсан ба тус хэлтсийн “Даатгал” баг гуравдугаар байр эзэлсэн амжилттай оролцсон. -Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласны дагуу АТГ-аас олон нийтийг соён гэрээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүргийн хүрээнд авлигын эсрэг “НЭГДЬЕ” үндэсний хэмжээний нөлөөллийн аянд хэлтсийн хамт

			олон нэгдэж, аяны профайлыг пэйж хуудсанд байршуулж ажилласан.
АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СУРГАЛТАНД ХАМРУУЛАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД			
2	2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон нийт албан хаагчдыг авлигын эсрэг сургалтанд хамруулсан байх;	-Шинэ томилогдсон болон нийт албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтанд бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх;	-Хэлтсийн даргын 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 296 тоот албан бичгээр хүргүүлсэн хүсэлтийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр АТГ-ын соён гэрээрүүлэх хэлтсийн ажилтан Д.Золжаргал “Авлигын гэмт хэрэг” сэдвээр сургалтыг танхимаар зохион байгуулсан ба сургалтанд албан хаагчид болон хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүд хамрагдсан.
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ БИЙ БОЛГОХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД			
3	3.1 НДЕГ болон хувийн хэвшлийн байгууллагын хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцласан тохиолдолд хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулсан байх; -Хэрэгжилтийн ач холбогдолыг үнэлж, дүгнэсэн байх; -Тайлан нотломжийг хавсаргасан байх;	

БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ, САНААЧИЛГА ӨРНҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД

5	5.2.Авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагааны хүрээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны ХЭГ-595 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр өгсөн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, дүнг хугацаанд гаргаж хүргүүлэх;	-Чиглэлийг мөрдөн ажилласан байна;	Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбоотойгоор төрийн бүх шатны байгууллагад “Шүгэл, шүүр, шувуу, шилжүүлэн авах, шил” ажиллагааг хэрэгжүүлж, нийтийн албанд хуульд заасан шаардлага хангаагүй этгээдийг томилохгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, авлига албан тушаалын гэмт хэргийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хангах, авлига албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон этгээдийг нийтийн албанаас шүүрдэх, цэвэрлэх, төрийн алба, төрийн өмчийг “шимэгчид”-ээс салгах ажлын хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шүүр” ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор ирүүлсэн чиглэлийн дагуу тус хэлтэст зөрчилтэй томилогдсон албан хаагч байхгүй болохыг 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр албан бичгээр НДЕГ-т хүргүүлсэн бөгөөд хүний нөөцийн албан томилгоонд уг чиглэлийг баримтлан ажиллаж байна.
	5.4.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэрээрүүлэх чиглэлээр тодорхой ажлыг санаачлан хийх талаар салбар нэгжийн дарга нарын	-Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байх;	Хэлтсийн дарга албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлж, Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ННДГ-ын дарга, төсвийн төвлөрүүлэн захирагч Г.Болорсүхтэй 4

	гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтэнд хяналт тавих;		зорилт, хийж хэрэгжүүлэх 57 ажил үйлчилгээ, Сүхбаатар дүүргийн Засаг дарга, Төсвийн ерөнхийлөн захирагч Х.Болормаатай 4 зорилт, хийж хэрэгжүүлэх 21 ажил үйлчилгээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан гүйцэтгэлийг хангаж ажилласан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.6-д “Төрийн албан хаагчийг авлига, хээл хахууль авах, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж ажиллах заалтыг оруулсан болно. Хэлтсийн 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны 4 зорилго, хийж хэрэгжүүлэх 10 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр гарган НДЕГ болон СБД ЗДТГ-т хүргүүлсэн ба жилийн тайланг 2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэхээр ажиллаж байна.
	5.5.Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг оруулж, хэрэгжилтэд хяналт тавих;	-Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байх;	Тус хэлтэс нь 2021 оны 03 дугаар сараас бүх албан хаагчидтай “Ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах гэрээ”-г байгуулан 2 хувь үйлдэж 1 хувийг төрийн албан хаагчийн хувийн хэрэгт, 1 хувийг нь албан хаагчид хүлээлгэн өгч гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг болно.
	5.6 Нийгмийн даатгалын үйлчилгээ авч байгаа иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах чиглэлээр зурагт хуудас түгээх;	-Зурагт хуудас хэвлүүлж түгээсэн байх;	

	5.7.Нийгмийн даатгалын салбарт хийгдсэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газрын цахим хуудас, facebook болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх ажлыг зохион байгуулах;	-Хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байх;	Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласны дагуу АТГ-аас олон нийтийг соён гэрээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүргийн хүрээнд авлигын эсрэг “НЭГДЬЕ” үндэсний хэмжээний нөлөөллийн аянд хэлтсийн хамт олон нэгдэж, аяны профайлыг пэйж хуудсанд байршуулж ажилласан.
	5.8.Дотоод нөөц бололцоог ашиглан албан хаагчдаа сургалт зохион байгуулсан байх;	-Албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх;	Хэлтсийн 2023 оны сургалтын төлөвлөгөөнд тусгасан төрийн албан хаагчийн ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон харилцаа хандлага, хууль дээдлэх зарчмын талаарх сургалтуудыг нийт албан хаагчдад зохион байгуулан ажиллав. Үүнд: “Амьдрах Урлаг” төрийн бус байгууллагаас “Стрессийн менежмент, түүнээс хэрхэн ангижрах” сэдэвт сургалт, сургалт судалгааны “Полиси” төсвийн багш Г.Эрдэнэгэрэл “Байгууллагын соёл, дотоод орчин” сэдвээр, “Хувь хүний сэтгэлзүй ба харилцаа” сэдвээр Их Засаг Их сургуулийн багш доктор, профессор Д.Чинцэцэг, Авилгатай тэмцэх газрын мэргэжилтэн Д.Золжаргал “Авилгын гэмт хэрэг” сэдвээрх сургалтуудыг тус тус танхимаар зохион байгуулсан. Мөн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалт хэлэлцүүлэгт тус хэлтсийн Ёс зүйн дэд

			хорооны дарга, гишүүд, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн болон бичиг хэрэг дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг 8 албан хаагч оролцов.
--	--	--	---